



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/410

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд шинээр гаргаж буй төрийн сангийн үйлчилгээний байрны засварыг түргэвчилж төрийн үйлчилгээний хэвийн байдлыг хангах зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдааны 4/03 дугаар тогтоолын 2 дугаар баталсан “Аймгийн орон нутгийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний жагсаалт”-ын 2.8-д батлагдсан арга хэмжээний санхүүжилтийн урьдчилгаанд 10000.0 мянган төгрөг /арван сая төгрөг/-ийг санхүүжүүлсүгэй.

2. Тус арга хэмжээг санхүүжүүлэх нийт 10000.0 мянган төгрөгийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 10000.0 мянга төгрөгийг аймгийн 2021 оны төсөвт тухайн зардлын батлагдсан эх үүсвэрээс нөхөн тооцоо хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D:\Zah-A\410-Bo  
02 2021